

Төрийн албаны зөвлөлийн
2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн
360 дугаар тогтоолын 12 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Аймаг дахь Газрын харилцаа, барилга,
хот байгуулалтын газар

Барилга, хот байгуулалтын хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Хот байгуулалтын кадастр, зураг
төсөл, магадлалын асуудал хариуцсан
мэргэжилтэн

Дэс түшмэл, ТЗ-5

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг.

Хаяг:

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭС

Албан тушаалын зорилго:

Салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг
эрхлэх, хот байгуулалтын баримт бичиг болон барилга байгууламжийн зураг төсөл
боловсруулах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг
хэлтсийн даргын өмнө хүлээнэ.

Албан тушаалын зорилт:

1. Салбарын хууль, тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, норм дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангах, шинэчлэх, боловсронгуй болгох санал боловсруулах;
2. Зураг төсөл, магадлал болон хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн бүрдүүлэлт, хөтлөхтэй холбоотой норм, дүрэм, журам, заавар, стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, хяналт тавих;
3. Аймаг, сум, суурины хэмжээнд хот төлөвлөлт, тохижилт, барилга байгууламж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн нэгдсэн мэдээллийн санг эрхлэх, хэрэгжилтийг хангах;
4. Салбарын инженер, техникийн ажилтнуудыг мэргэшүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах;
5. Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, дотоод ажлыг зохион байгуулах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
	<p>1. Холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, байгууллагын стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт тусгагдсан зорилтын хэрэгжилтийг дунд, богино хугацаанд оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах</p> <p>2. Салбарын хууль тогтоомж болон холбогдох хууль тогтоомж тэдгээрт нийцүүлэн гарах хэм хэмжээний акт, бусад баримт бичгийг боловсруулахад санал өгөх, хэрэгжүүлэх;</p>	Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байх.	Г
	<p>3. Хот байгуулалтын салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хангах сурталчлах, иргэн, хуулийн этгээдийг зөвлөгөө, мэдээллээр хангах;</p>	Судалгаа, дүгнэлт бодитой хийгдсэн байна.	Г
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>4. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сантай холбоотой норм нормативын баримт бичигт дэвшилтэд, шинэ техник, технологийг судлах, тусгуулах, шинэчлэх, нэвтрүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах судалгаа хийх, үнэлэлт дүгнэлт өгөх.</p>	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	<p>1. Мөрдөгдөж буй зураг төсөл, магадлал болон хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн талаарх заавар, дүрэм, журам, норм, стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавьж ажиллах;</p> <p>2. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн мэдээлэл бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах;</p>	<p>Заавар, дүрэм, журам, норм, стандартыг хэрэгжүүлсэн байх</p> <p>Мэдээлэл үнэн зөв байна.</p>	<p>Г</p> <p>Г</p>



2 дугаар зорилтын хүрээнд	3.Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сантай холбоотой норм нормативын баримт бичигт дэвшилтэд, шинэ техник, технологийг судлах, тусгуулах, шинэчлэх, нэвтрүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	4.Хот байгуулалтын үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх мэдээллийн сангаас гарах мэдээлэлд дүн шинжилгээ хийх;	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г,Х
	5.Хотын ерөнхий төлөвлөгөө, барилгын төсөл, хэрэгжүүлэх үе шатны төлөвлөгөөтэй уялдуулан шинээр барих барилга байгууламжийн байршилд хангагч болон бусад мэргэжлийн байгууллагуудын саналыг авч тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгөх.	Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	6.Хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ, нийтийн аж ахуйн үйлдвэрлэл үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих;	Зохицуулалт нь хууль болон ёс зүйн хэм хэмжээнд нийцсэн байна.	Г
	7.Хот, байгуулалтын баримт бичиг боловсруулах, барилга, барилгын материалын үйлдвэрлэл явуулах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг мэргэжил, арга зүйгээр хангах, орон нутгийн хэмжээнд мэдээллийн сан үүсгэж, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Г,Х
	1.Аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдэл бүрдүүлэх, хөтлөх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2.Аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангаас барилга байгууламж, тохижилт, нийгмийн болон дэд бүтцийн үзүүлэлтээр нэгдсэн судалгаа, мэдээ тайлан, дүгнэлт гаргах;	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	



3 дугаар зорилтын хүрээнд	3.Хот байгуулалтын кадастрын мэдээллийн ил тод, үнэн зөв байдлыг хангах, шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийг шийдвэрлүүлэх санал боловсруулах;	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	4.Хот байгуулалтын кадастрын мэдээллээр Засаг дарга бусад бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, хэрэглэгчдийг хангах;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	5.Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг холбогдох байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулах талаар хамтран ажиллах,	Мэдээлэл үнэн зөв байна.	Г
	6.“Зураг төсөл боловсруулах, зөвшөөрөх батлах дүрэм” “Зураг төсөл хайгуулын ажилд экспертиз хийх дүрэм”-ийн дагуу зураг төсөлд экспертиз хийлгэхэд мэргэжлийн зөвлөмж дэмжлэг үзүүлэх, зөвшилцэх.	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	1.Барилга, хот байгуулалтын салбарын инженер, техникийн ажилтнуудыг мэргэшүүлэх болон гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах;	Салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийн чадавх дээшилсэн байна.	Г
	2.Зураг төсөл, магадлалын чиглэлээр шинээр батлагдсан норм стандарт, дүрэм, журам бусад эрх зүйн барим бичгээр сургалт хийх, иргэн, хуулийн этгээдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	3.Орон нутагт барилгын салбарын мэдээллийн нэгдсэн санг бий болгож, баталгаат мэдээллээр иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх;	Олон нийтэд зөв, бодитой мэдээллийг хүргэсэн байна.	Г
	4.Орон нутгийн хэмжээнд хийгдсэн судалгаа, хэрэгжиж буй төсөл, хетөлбөр, хууль, тогтоомжийн хэрэгжилт, зохион байгуулсан арга хэмжээ, хүрсэн үр дүн, мэдээллийн сангийн талаар олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулах.	Олон нийтэд зөв, бодитой мэдээллийг хүргэсэн байна.	Г
	5.Зураг төсөл, магадлалын чиглэлээр зохион байгуулагдах хурал, зөвлөгөөн, сургалт, семинарт оролцож салбарын бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Г
	6.Зураг төсөл, магадлалын чиглэлээр холбогдох байгууллагуудад мэргэжлийн санал, зөвлөмж дэмжлэг үзүүлэх, иргэд, албан байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, судлан	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Г



	шийдвэрлэх.		
	7.Батлагдсан байршлын схемын дагуу архитектур төлөвлөлтийн даалгаварыг боловсруулан батлуулж хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд оруулах ажлын зохион байгуулах.	Олон нийтэд зөв, бодитой мэдээллийг хүргэсэн байна.	Г
	8.Барилга байгууламжийн зураг төслийн бүрэн байдал, түүнд хийгдсэн экспертизийн дүгнэлт, барилга угсралтын технологийн горим, стандарт, хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг хяналтын эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах, оролцох;	Олон нийтэд зөв, бодитой мэдээллийг хүргэсэн байна.	Г
	9.Зураг төсөл, магадлал, хот байгуулалтын кадастр, төсөл, хөтөлбөрийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлын тооцоо, төсөвт тусгуулах санал боловсруулах, танилцуулах, хэрэгжүүлэх.	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт хангагдсан байна.	Г
5 дугаар зорилтын хүрээнд	1.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, дотоод ажлыг зохион байгуулах;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2.Байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хариуцсан ажлын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлын тооцоо, төсөвт тусгуулах санал боловсруулж, нэгжийн даргад танилцуулах, хэрэгжүүлэх;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт хангагдсан байна.	Г
	3.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сар, улирал, хагас жилээр гаргаж, нэгжийн даргад тайлагнах;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт хангагдсан байна.	Г
	4.Үнэлгээний хороо болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах;	Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна.	Г
	5.Байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн хурал, удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, цаг үеийн шаардлагаар гарсан ажлуудыг тухай бүр зохицуулан зохион байгуулах, биелэлтийг хангаж, тайлагнах;	Хамрагдсан хурал, уулзалт, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдсан байна.	Г
	6.Байгууллагын дотоод дүрэм, журам, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллах, төрийн захиргааны манлайллыг хэрэгжүүлэх;	Дүрэм, журам ёс зүйн хэм хэмжээнд заасан манлайлал бий болсон байна.	Г
	7.Хариуцсан үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн	Архивын ажлын үндсэн зааварт нийцсэн байна.	Г



	нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивд хүлээлгэн өгөх;		
	8.Байгууллагын болон нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаа, хурал, сургалт, олон нийтийн арга хэмжээнд оролцох.	Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА:

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	-Газар зохион байгуулалт /газрын кадастр, үнэлгээ, төлөвлөлт/ /073101/; -архитектур, хот төлөвлөлт /073102, 073103/; -иргэний ба үйлдвэрийн барилга, байгууламж /0732/.
Мэргэшил	Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна.
Туршлага	Туслах түшмэл болон түүнээс дээш ангиллын албан тушаалд эсхүл мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласан байх.
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх <ul style="list-style-type: none"> - Судалгааны арга зүй эзэмшсэн байх; - мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; - байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх; - судалгааны үр дүнг харьцуулан үнэлэх, тайлбарлах; - нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; - мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх; - өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх мэдлэг, чадвартай байх; - асуудлын шийдэлд шинэлэг байдлыг нэвтрүүлдэг байх; - бусад.
	Багаар ажиллах <ul style="list-style-type: none"> - Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч байж, бусдыг дэмжих; - шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг нэвтрүүлэх; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх; - бусад.
	Бусад <ul style="list-style-type: none"> - Газар зүйн мэдээллийн системийн arcgis, quantum gis, erdas imagine, autocad, postgis, land manager, pycharm, postgres програм хангамжийг эзэмшсэн байх; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл,

		найруулга зүйн чадвартай байх; - багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дүгнэх, нэгжийн хамт олонд таниулах; - харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх; - үндэсний бичгийн хэлээр уншиж бичих чадвартай байх; - төрийн болон хувь хүний нууцыг хууль тогтоомжийн хүрээнд хадгалах, хамгаалах.
--	--	---

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
- Хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьялан
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

- Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс;
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан;
- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА

Ц.ГАНХҮҮ

2020 оны 11 дугаар сарын 04 -ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо:

20 1104

Дугаар: 3.60.

VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

Байгууллагын нэр:

АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар:

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

2020 оны 12 дугаар сарын -ны өдөр

